



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/281

Улаанбаатар хот

ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл шалгаруулах удирдамж батлах, төсөл сонгон шалгаруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.16, 10.2 дэх заалт, ШУТИС-ийн Ректорын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/410 дугаар тушаалаар баталсан “ШУТИС-д эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, судалгаа инновацын үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 4.6.1, 4.6.2, 6.1.3, 6.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн 2027 онд санхүүжүүлэх судалгаа, инновацын төсөл, докторын дараах судлаачийн тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг 2026 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дотор зохион байгуулсугай.
2. 2027 онд ШУТИС-ийн санхүүжилттэй судалгаа, инновацын төсөл сонгон шалгаруулах удирдамжийг 1-р хавсралтаар, докторын дараах судлаачийн тэтгэлэгт хөтөлбөрийн удирдамжийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.
3. Төслийн сонгон шалгаруулалтыг удирдамжийн дагуу хийж шалгарсан төслүүдэд санхүүжилт олгох, хэрэгжилтэд хяналт тавьж зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөл (Д.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

РЕКТОР



Т.НАМНАН

367041039

**ШУТИС-ИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ СУДАЛГАА, ИННОВАЦЫН ТӨСӨЛ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Зорилго:

ШУТИС-ийн судалгаа, инновацын хөгжилд хувь нэмэр оруулахуйц улс орны нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий судалгааны төслүүдийг сонгон шалгаруулж, 2027 онд санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

Төслийн төрөл:

ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн алба, Инновац, бизнес түншлэлийн албаас 2027 онд хэрэгжүүлэх (1) **суурь, хэрэглээний судалгаа /онолын суурь ШУ-ыг хөгжүүлэх/,** (2) **технологийн туршилт, зүгшрүүлэлт /судалгааны үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх/,**-ийн төслийг сонгон шалгаруулж санхүүжүүлнэ.

Тавигдах шаардлага:

Төсөл нь дараах шаардлага, шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Төсөл мэдүүлэх судалгааны багийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны (харьяа хүрээлэнгийн судлаачид хамаарна) доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэгтэй профессор, багш, судлаач байна;
2. Төслийн багийн гишүүдийн тоог хязгаарлахгүй бөгөөд төслийн багт хоёр ба түүнээс дээш ШУТИС-ийн үндсэн болон гэрээт профессор багш, судлаач, ажилтан, докторын хөтөлбөрийн сургалт, эрдэм шинжилгээний багц цагийг бүрэн дүүргэсэн /36 кредитээс доошгүй/ 1-2 оюутныг заавал оролцуулна;
3. Судалгааны төслийг хэрэгжүүлэх хугацаа суурь судалгаа - **17 сар**, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл - **24** сараас хэтрэхгүй байна;
4. Судалгааны үр дүнг эзэмших, ашиглахыг ШУТИС-д зөвшөөрсөн байна;
5. “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний үндсэн зорилгын хангах үзүүлэлтүүдэд хувь нэмэр оруулсан байна;

№	Төсөлд тавигдах шаардлага:	
	Суурь, хэрэглээний судалгаа	Технологийн туршилт, зүгшрүүлэлт
1	ШУТИС-ийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд онолын суурь хэрэглээний шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн бөгөөд шийдвэрлэх асуудал нь тодорхой, оновчтой судалгааны арга замыг сонгосон байх;	Судалгааны үр дүнгээр шинэ бүтээлийн патент, ашигтай загвар патент, бүтээгдэхүүний загварын патентын аль нэг төрлөөр хамгаалалт хийлгэсэн бөгөөд патентын гэрчилгээ нь хүчинтэй байх;
2	Олон улсын мэдээллийн сан WoS, Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр 1-ээс доошгүй өгүүлэл хэвлүүлэх; (Судлаач нь хэвлэн нийтлүүлсэн ажлууддаа “ШУТИС-ийн судалгаа, инновацыг дэмжих санхүүжилтээр” гэдгийг заавал дурдана.)	Судалгааны үр дүнг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээнд туршин нэвтрүүлэхдээ дараах 2 нөхцөлийн аль нэгийг сонгосон байх; 1. Лицензийн гэрээгээр зах зээлд нэвтрүүлэх; 2. Гарааны компани байгуулж зах зээлд нэвтрүүлэх; (Гарааны компани байгуулах мэдүүлгийг тооцно)



3	Дэвшүүлж буй судалгааны чиглэлээр ШУТИС-д суралцаж буй 1-2 докторантыг “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийн холбогдох заалт (6.1) - ын дагуу Докторант хамгаалалтад ороход тавигдах шаардлагыг бүрэн хангуулсан байх;	Төслөөр хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетинг болон бизнес төлөвлөгөөг боловсруулан өрсөлдөх чадвар (зах зээл, үр ашиг, түүхий эд материалын талаарх тооцоо, судалгаа)-ийг илэрхийлсэн байх;
4	- Судалгааны үр дүнгээр зохиогчийн эрхийн гэрчилгээ, шинэ бүтээлийн патент, ашигтай загвар патент, бүтээгдэхүүний загварын патентын аль нэг төрлөөр хамгаалалт хийлгэсэн байх; (Анхдагч огноо авсан патентын мэдүүлгийг тооцно.) - Ном, сурах бичиг, гарын авлагын аль нэгийг хэвлүүлэх	Төслийн судалгаа хөгжүүлэлтийн үе шат 6 сар (бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргах), үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх үе шат 18 сар төслийн нийт үргэлжлэх хугацаа 24 хүртэлх сар байх;
5	Судалгааны үр дүнг мэргэжлийн чиглэлийн эрдэм шинжилгээний хурал болон ШУТИС-ийн багш, судлаачдын дунд хэлэлцүүлж, түгээн дэлгэрүүлэх;	Төслийг амжилттай хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавх (бусад эх үүсвэрээс хамтарсан санхүүжилт авсан бол давуу тал болох)-тай байх;
6	Төслийн санхүүжилтийн нийт дүн: Эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй 30 сая хүртэлх төгрөг байна.	Төслийн санхүүжилтийн нийт дүн: 80% нь эргэн төлөгдөх нөхцөлтэй 50 сая хүртэлх төгрөг байна.

Төслийн материал бүрдүүлэх, төсөл ирүүлэх, шалгаруулах хугацаа

- Бүрдүүлэх материал:** Төсөл санаачлагч баг нь доорх материалыг бүрдүүлэн Эрдэм шинжилгээ, технологи, хөгжүүлэлтийн албанд ирүүлнэ.
 - Судалгааны баг нь дэвшүүлэх төслийн саналаа “төсөл мэдүүлэх заавар маягт”-ын дагуу боловсруулж, PDF форматаар research@must.edu.mn цахим хаягаар ирүүлнэ (Материал дутуу ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй);
 - Тухайн судалгааны сэдвийн давтагдаагүй байдал, гарах үр дүнгийн төсөөллийн саналыг төслийн удирдагчийн харьяалах бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн хурлын тэмдэглэл, захирлын албан бичгийн хамт;
- Материал хүлээн авах:** Төслийн материалыг 2026 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 18:00 цагт хүртэл Эрдэм шинжилгээ, технологи, хөгжүүлэлтийн албанд цахимаар болон цаасаар хүлээн авна.
- Төслийн санал хянах:** Ирүүлсэн төслийн саналын материал бүрэн эсэх, тавьсан шаардлагад нийцэж буй эсэхийг Эрдэм шинжилгээ, технологи, хөгжүүлэлтийн алба хянан магадалгаа хийж, шаардлага хангасан төслүүдийг шалгаруулалтад урина.
- Сонгон шалгаруулах:** Шаардлагад нийцсэн төслүүдийг 2026 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дотор ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлөөр нээлттэй хэлэлцэж, эцсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

ШУТИС-ийн ректорын 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн
A/283 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

Эрдэмтэн судлаач Та бүхнийг ШУТИС-ийн Ректорын 2025 оны 12 дугаар сарын 24-ний
өдрийн A/410 тоот тушаалын хавсралтаар баталсан “ШУТИС-д Эрдэм шинжилгээний
төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, судалгаа, инновацын үйл ажиллагааг санхүүжүүлэх
журам”-ыг баримтлан, удирдамжийн дагуу төслийн баримт бичгийг боловсруулан сонгон
шалгаруулалтад оролцохыг урьж байна.

-oOo-



ШУТИС-ИЙН ДОКТОРЫН ДАРААХ СУДЛААЧИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

I. Удиртгал

Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр эрдмийн зэрэг (Ph.D.) хамгаалсан, эрдэмтдийн залгамж хойч үе болсон залуу судлаачдын бие даан эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж, үр дүнд инновац бий болгох, Монгол улсын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах, түүнчлэн олон улсын түвшинд өрсөлдөхүйц судлаачдын багийг хөхүүлэн дэмжих зорилгоор, докторын дараах судалгааны төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тэтгэлэгт хөтөлбөрийг зарлаж байна.

II. Хөтөлбөрийн үндсэн зорилго

Дэвшилтэт судалгааг дэмжих: Монгол улсын тогтвортой хөгжлийг (ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны үндсэн чиглэлийн сэдвийн хүрээнд) өндөр түвшний судалгааг санхүүжүүлэх

Олон улсын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх: Олон улсын Scopus, WoS мэдээллийн санд бүртгэлтэй эрдэм шинжилгээний өндөр нөлөөлөл бүхий сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, гадаадтай хамтарсан төсөл, грант босгох, олон улсын нэр хүнд бүхий шинжлэх ухаан, инновацын сүлжээнд нэгдэх

ШУТИС-ийн академик нэр хүндийг дээшлүүлэх: Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд бий болсон шилдэг судалгааны үр дүнгээр их сургуулийнхаа нэр хүндийг өсгөх

III. Судлаачдад тавигдах ерөнхий шаардлага

- Докторын (Ph.D.) зэрэг хамгаалсан, эрдмийн зэрэг хамгаалснаас хойших хугацаа 5 жилээс хэтрээгүй байх
- Олон улсын мэдээллийн сан (Web of Science, Scopus)-д бүртгэлтэй сэтгүүлд өөрийн судалгааны үр дүнгээр 1 дүгээр зохиогч, эсвэл холбоо баригч зохиогчоор эрдэм шинжилгээний 2-оос доошгүй өгүүлэл хэвлүүлсэн байх
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль/хүрээлэн, тэнхимийн дэмжлэгтэй байх, гадаад дотоодын судалгааны төсөлд оролцсон байх
- ШУТИС-ийн үндсэн орон тооны багш, ажилтан эсвэл гэрээт ажилтан байх

IV. Судалгааны төслийн боловсруулалт

Докторын дараах судлаачийн тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцох судалгааны төслийг боловсруулахдаа дараах агуулгыг багтаасан байна.

- 3.1. Хураангуй (*Abstract*)
- 3.2. Судалгааны үндэслэл, ач холбогдол (*Background and Rationale*)
- 3.3. Судалгааны зорилго, зорилтууд (*Research Aims and Objectives*)
- 3.4. Судалгааны арга зүй (*Methodology*)
- 3.5. Хүлээгдэж буй үр дүн ба нөлөө (*Expected Outcomes and Impact*)
- 3.6. Хугацааны төлөвлөгөө/ Ажлын хуваарь (*Timeline/ Work Plan*)
- 3.7. Судлаачийн болон судалгааны ёс зүйн асуудлууд (*Ethical Considerations*)

V. Хөтөлбөрийн хэрэгжилт, тайлан

- Тэтгэлгийн хугацаа: 1,5 жил хүртэл
- Санхүүжилтийн хэмжээ: 10.000.000 (арван сая) төгрөг хүртэл

ШУТИС-ийн ректорын 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн

A/281 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

- Web of Science, Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр 1-2 өгүүлэл хэвлүүлнэ.

- Судлаач нь хэвлэн нийтлүүлсэн ажлуудаа "ШУТИС-ийн Докторын дараах судлаачийн тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтээр" гэдгийг заавал дурдана.

Жишээ нь: Энэ ажлыг ШУТИС-ийн докторын дараах тэтгэлэгт хөтөлбөр [Грант ID] дэмжсэн

This work was supported by MUST Postdoctoral Research Fellowship Program [Grant ID]

- Судлаач нь ахисан түвшний сургалтын 1-2 оюутныг судалгааны ажилд оролцуулж, төгсөлтийн ажлыг удирдаж хамгаалуулна.

- Судлаач нь судалгааны ажлын явц, үр дүнгийн явцыг улирал тутам бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлд, төсөл дуусахад мөн бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл, ШУТИС-ийн ЭШТ-ийн дэд зөвлөлд судалгааны үр дүн, санхүүгийн тайланг гаргаж тайлагнана.

VI. Судалгааны төслийг үнэлэх шалгуур

Шалгуур үзүүлэлт	Хувь	Дэлгэрэнгүй мэдээлэл
Судалгааны ажлын чанар <i>Research Proposal Quality</i>	30%	Инновац, арга зүй, хэрэгжих боломж
Академик амжилт <i>Academic Excellence</i>	30%	Impact Factor-тай сэтгүүлд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, ололт амжилт
Боловсролын замнал <i>Educational Background</i>	10%	Олон улсын түвшинд суралцсан, хамтран ажилласан туршлага
Их сургуулийн судалгаанд үзүүлэх нөлөө <i>The Impact on University Research</i>	20%	ШУТИС-ийн эрдэм судлалын ажлын стратегийн чиглэлүүдтэй нийцсэн төсөл
Нийгмийн нөлөө <i>Social Impact</i>	10%	Монгол улсын хөгжилд үзүүлэх эерэг нөлөөлөл

Жич: Олон улсын төсөлд оролцсон ба гадаадын их сургуультай хамтран ажилласан туршлагатай бол онцгой давуу тал болно

VII. Бүрдүүлэх материал ба өргөдөл хүргүүлэх заавар

Бүрдүүлэх материал

1. Бүрэн бөглөсөн докторын дараах судлаачийн тэтгэлэгт хөтөлбөрийн өргөдлийн маягт

MUST PostDoc Маягтыг татаж авна уу

2. Судалгааны төсөл- Өргөдлийн маягтын 3 дугаар хэсгийг 5-аас хэтрэхгүй хуудсанд багтааж дэлгэрүүлэн бичнэ.
3. Докторын зэрэг хамгаалсан дипломын хуулбар, дүнгийн хавсралт (e-Mongolia)
4. Хэвлэн нийтлэлийн баталгаа (2 гол өгүүллийн нүүр хуудасны хуулбар, DOI дугаар)
5. Бүтээлийн жагсаалт (баталгаажуулсан байх)
6. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгээс дэмжсэн бичиг (албаны хэвлэмэл хуудас дээр бичигдэж, research@must.edu.mn хаяг руу шууд илгээгдсэн байх)

ШУТИС-ийн ректорын 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн
А/281 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

7. Бусад холбогдох баримт бичиг (шагнал, сертификат гэх мэт)
8. Дээрх бичиг баримтыг цахимаар болон цаасаар ирүүлэх



Өргөдөл хүргүүлэх заавар

1. Дээрх бүх материалыг нэг PDF файл болгон нэгтгэж илгээнэ. (Файлын хэмжээ хамгийн ихдээ 15Mb байна)
 - [Таны овог, нэр]_PostDoc_Application.pdf гэж нэрлээд, [research@must.edu.mn И-Мэйл хаяг]-руу илгээнэ.
 - И-Мэйлийн гарчигт "Докторын дараах судлаачийн тэтгэлгийн өргөдөл"- [Таны овог, нэр]
2. Өргөдлийг 2026 оны 10 сарын 16-ны өдрийн 18:00 цаг хүртэл Эрдэм шинжилгээ, технологи, хөгжүүлэлтийн албанд цахимаар болон цаасаар хүлээн авна.

VIII. Сонгон шалгаруулалт

1. Ирүүлсэн материал бүрэн гүйцэд, тавьсан шаардлагад нийцэж буй эсэхийг Эрдэм шинжилгээ, технологи, хөгжүүлэлтийн албанд хянан магадалгаа хийж, шаардлага хангасан судлаачдыг шалгаруулалтад урина.
2. Шаардлагад нийцсэн судалгааны төслийн эцсийн сонгон шалгаруулалтыг 2026 оны 11 сарын 13-ны өдрийн дотор зохион байгуулна.
3. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлийн хурлаар шалгарсан судалгааны төслүүдийг нээлттэй хэлэлцэн, докторын дараах судлаачийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах судлаачдыг сонгож, эцсийн шийдвэрийг гаргана.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТЕХНОЛОГИ, ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЛБА

АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ

-oOo-